КАЗИНО БАЙГУУЛАХ, АЖИЛЛУУЛАХЫГ ХОРИГЛОХ ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ БОЛОН КАЗИНО, БООЦООТ ТОГЛООМЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХИЙГ ЗӨВШӨӨРДӨГ ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА

(Харьцуулсан судалгаа)

Ц.Болормаа, Ч.Онончимэг, Д.Халиун, Ц.Элбэгзаяа

АГУУЛГА

Нэг. Казино байгуулах, ажиллуулахыг хориглох тухай Монгол Улсын эрх зүйн зохицуулалт

Хоёр. Ерөнхий мэдээлэл
- 2.1. Казино, бооцоот тоглоомын үйл ажиллагааны талаарх ерөнхий мэдээлэл
- 2.2. Казино, бооцоот тоглоомын үйл ажиллагааны бизнесийн бусад салбарт үзүүлэх нөлөөлөл
- 2.3. Казино, бооцоот тоглоомын нийгэмд үзүүлэх сөрөг үр дагаврааc хамгаалах механизм

Гурав. Гадаадын зарим орны туршлага
- 3.1. БНСУ
- 3.2. АНУ
- 3.3. Сингапур
- 3.4. Макао

ОРШИЛ

Судалгааны зорилго

Энэхүү судалгаанд казино, бооцоот уралдаан, тэмцээний газрыг байгуулахыг зөвшөөрдөг улс орнуудын эрх зүйн зохицуулалт, түүнчлэн казиногийн эдийн засаг, нийгэмд үзүүлэх нөлөөлөл, үр дагавар, казино, бооцоот тоглоомын үйл ажиллагаанаас олох жилийн орлого, эдийн засагт эзэлж буй хувь хэмжээ болон Казино байгуулах, ажиллуулахыг хориглох тухай Монгол Улсын хуулиудын талаар судлахыг зорилоо.

Судалгааны хамрах хүрээ

Судалгаанд АНУ, БНСУ, Макао, Сингапур улсуудын казиногийн үйл ажиллагаа явуулах эрх зүйн ерөнхий зохицуулалт, түүнчлэн казиногийн эдийн засаг болон нийгмийн салбарт үзүүлэх эерэг, сөрөг үр нөлөө, нийгэмд үзүүлэх сөрөг үр дагаврааc хамгаалах механизм зэрэг мэдээллийг хамруулав.

Түүнчлэн АНУ, БНСУ, Макао, Сингапур улсуудын казино, бооцоот тоглоомын орлогын хэмжээг жилээр харьцуулан гаргаснаас гадна бооцоот тоглоомын орлогод ногдуулдаг татварын төрөл, хувь хэмжээ, мөн энэ төрлийн татварын орлогын хуваарилалтын талаар АНУ-ын 22 мужийн туршлагыг харьцуулан судаллаа.

Монгол Улсын хувьд казино байгуулах, ажиллуулахыг хориглох тухай хуулийг 1999 оны 1 дүгээр сарын 22-ны өдөр баталсан бөгөөд энэхүү хуулийн үзэл баримтлал, эрх зүйн зохицуулалтын талаар товч авч үзсэн болно.

НЭГ. КАЗИНО БАЙГУУЛАХ, АЖИЛЛУУЛАХЫГ ХОРИГЛОХ ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Манай улсын хувьд анх 1998 оны 1 дүгээр сарын 15-ны өдөр Казиногийн тухай хуулийг батлан гаргаж Монгол Улсад казиногийн бүхий л үйл ажиллагаа эрхлэхийг зөвшөөрсөн. Гэвч Казиногийн тухай хуулийг батлан гаргахдаа тухайн үеийн нийгэм, эдийн засгийн байдал, Казиног даган гарах гэмт хэрэг, зөрчил, мафийн сүлжээ гэх мэт сөрөг үр дагавар зэргийг харгалзаж үзээгүй байна.

Энэ хуультай холбоотойгоор нийгэмд хүчтэй шүүмжлэл өрнөж, 1999 онд нэр бүхий Монгол Улсын Их Хурлын гишүүд Казино байгуулахыг хориглох тухай болон Казиногийн тухай хуулийг хүчингүй болгох тухай хуулийн төслүүдийг Улсын Их Хуралд өргөн барьж дэмжигдсэнээр Казиногийн тухай хууль хүчингүй болж, 1999 оны 1 дүгээр сарын 22-ны өдөр “Казино байгуулах, ажиллуулахыг хориглох тухай” Монгол Улсын хууль батлагдсан байна. Энэ хууль нь нэг зүйлтэй батлагдсанаас хойш 2003 онд нэг удаа нэмэлт орсон байна.

Монгол Улсад чөлөөт бүсээс бусад газарт Казино байгуулах, ажиллуулахыг хориглосон заалт Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгагдсан байдаг. Мөн Эрүүгийн хуулийн 243.1 дэх заалтаар казино зохион байгуулах, орон байраар хангах, түүгээр тоглосон бол шийтгэх хориглосон заалттай байгаа. Гэтэл Замын-Үүд эдийн засгийн чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай хуульд казино байгуулж болохоор заасан байна.

Хүснэгт 1. Казино байгуулах, ажиллуулахыг хориглох тухай хуультай холбоотой хуулиуд

д/д	*Хуулийн нэр*	*Батлагдсан огноо*	*Зохицуулалт*
1	Замын-Үүд эдийн засгийн чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай	2003.06.20	3.3. “Замын-Үүд” бүсэд казино байгуулж болно.
2	Эрүүгийн хууль	2002.01.03	**243 дугаар зүйл. Мөрийтэй тоглох** 243.1.Хуулиар хориглосон мөрийтэй тоглоом (**казино**) **тоглосон, түүнийг зохион байгуулсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.** 243.2.Энэ хэргийг давтан үйлдсэн бол эд хөрөнгийг хурааж хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
3	Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай	2001.02.01	8.1.3. казиногийн үйл ажиллагаа эрхлэх;

Мөн Улсын Дээд Шүүхийн 2006 оны 36 тоот тогтоолоор Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3 дахь хэсгийн “Казиногийн үйл ажиллагаа эрхлэх»-ийг хориглох гэдэгт мөнгө буюу түүнийг орлогч металл (токенс) хэрэглэн тоглодог электрон хэрэгсэл, слот машин, мөн тоглоомын үйл ажиллагаанд мөнгийг орлуулан хэрэглэх зориулалтын тусгай хуванцар зоос (чип) буюу шоо, хөзөр,

тэдгээрт зориулсан тоглоомын тусгай ширээ зэрэг казиногийн зориулалтаар өрөө, тасалгаа, тоног, төхөөрөмжийг ашиглан үр дүнг нь урьдчилан төсөөлөх боломжгүй, аз туршсан тоглоом тоглуулах зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно гэж тайлбарласан байна.

Улаанбаатар хотод 1950-60-аад оны үед морин тойруулга буюу ипподром ажиллаж, бооцоот морин уралдаан тогтмол явагддаг байжээ. Мөн Улаанбаатарын гудамжинд албан байгууллагууд лото тоглуулан ажилтнууддаа зориулсан хуримтлал үүсгэхийг зөвшөөрдөг байсан байна.

ХОЁР. КАЗИНО, БООЦООТ ТОГЛООМЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

2.1. Казино, бооцоот тоглоомын үйл ажиллагааны талаарх ерөнхий мэдээлэл

2011 оны байдлаар Казиногийн тоо хэмжээгээр Хойд Америкийн бүс нутаг тэргүүлж байгаа бөгөөд нийт 1623 казино ажиллаж байгаа гэсэн тоо гарсан байна. Үүнээс АНУ-ын хувийн өмчийн 426 казино тоглоомын газар байх бөгөөд тэдгээр нь гадаад, дотоодын иргэдэд нээлттэй байдаг бол, зөвхөн Америкийн уугуул иргэдэд үйлчилдэг казино тоглоомын газар байдаг байна.

Зүүн Азийн улс орнуудаас БНСУ-д үйл ажиллагаа явуулдаг казино нь эдийн засгийн чөлөөт бүсэд байрлах бөгөөд дотоодын иргэдэд үйлчлэх эрх бүхий Кангвоны казино тоглоомын газар байна. Сингапур болон Макаогийн казино тоглоомын газар дотоодын иргэдэд нээлттэй боловч нэвтрэх төлбөрийн хувьд Сингапур хамгийн өндөр төлбөртэй байх бөгөөд нэг хүн нэг удаа нэвтрэхдээ 100 SGD төлдөг байна.

Казиногийн орлогын ерөнхий мэдээллийг бүсээр нь авч үзвэл 2009-2011 оны байдлаар дараах үзүүлэлт гарсан бөгөөд АНУ тэргүүлсэн үзүүлэлт гарсан байна. Статистикийн портал сайтаас гаргасан дэлхийн улс орны казиног бүсээр нь ангилсан графикийг авч үзье.[39]

Зураг 1. 2011 оны байдлаар казиногийн тоо бүсээр, 2011 оны байдлаар



Казиногийн тоон хэмжээгээр Хойд Америкийн бүс нутаг тэргүүлж байгаа бөгөөд 2011 оны байдлаар нийт 1623 казино ажиллаж байгаа гэсэн тоо гарсан байна. Үүнээс АНУ-ын хувийн өмчийн 426 казино тоглоомын газар байх бөгөөд гадаад, дотоодын иргэдэд нээлттэй, харин зөвхөн Америкийн уугуул иргэдэд зөвхөн тэдэнд зориулсан казино тоглоомын газар нээлттэй байдаг байна.

[39]http://www.statista.com/search/?q=casino

Харин Зүүн Азид байх казино, бооцоот тоглоомын үйл ажиллагаа эрхлэгч орнуудаас Макао, БНСУ, Сингапурын казино тоглоомын зах зээл, жилийн орлого, татварын талаарх харьцуулсан мэдээллийг судалгааны тайлангийн 2 дугаар хэсэгт багтаасан болно.

Зүүн Азийн улс орнуудаас БНСУ-д үйл ажиллагаа явуулдаг казино нь эдийн засгийн чөлөөт бүсэд байрлах бөгөөд дотоодын иргэдэд үйлчлэх эрх бүхий Кангвоны казино тоглоомын газар байна.

Сингапур болон Макаогийн казино тоглоомын газар дотоодын иргэдэд нээлттэй боловч нэвтрэх төлбөрийн хувьд Сингапур хамгийн өндөр төлбөртэй байх бөгөөд нэг хүн нэг удаа нэвтрэхдээ 100 SGD төлдөг байна.

Казиногийн орлогын ерөнхий мэдээллийг бүсээр нь авч үзвэл 2009-2011 оны байдлаар дараах үзүүлэлт гарсан бөгөөд АНУ тэргүүлсэн үзүүлэлт гарсан байна.

Хүснэгт 2. 2009-2011 оны казиногийн орлогыг бүсээр нь нь харьцуулсан мэдээлэл

Зэрэглэл	*Байрлал*	*Казино*	*Орлого (2009) сая ам.доллар*	*Орлого (2010 Projected) сая ам.доллар*	*Орлого (2011 Projected) сая ам.доллар*
1	United States		57,240	56,500	58,030
2	AsiaHYPERLINK “http://en.wikipedia.org/wiki/Pacific”Pacific		21,845	32,305	41,259
3	Europe, Middle East, Africa		17,259	16,186	16,452
4	Canada	22	3,712	3,835	4,045
5	Latin America		425	528	594
	Total		**100,481**	**109,354**	**120,380**

Харин зах зээлийн орлогоор нь харьцуулахад 2009-2011 оны харьцуулсан мэдээллээр Макао, Лас Вегас, Сингапур, Францын казино тоглоомын газар эхний 4-т орсон байна.

Хүснэгт 3. 2009-2011 оны казиногийн орлогыг зах зээлээр нь харьцуулсан мэдээлэл

Зэрэглэл	*Байрлал*	*Казино*	*Орлого (2009) сая ам.доллар*	*Орлого (2010 Projected) сая ам.доллар*	*Орлого (2011 Projected) сая ам.доллар*
1	Macau	33	14,955	22,445	28,379
2	Las Vegas, United States	122	10,247	9,950	10,300
3	Singapore	2	2,119	2,750	5,479
4	France	1	3,965	3,909	3,957
5	Atlantic City, United States	12	3,943	3,550	3,330
6	Australia	11	2,697	2,769	2,847
7	South Korea	17[13]	2,401	2,430	2,512
8	Germany	76	2,073	2,055	2,081
9	South Africa	4	1,601	1,649	1,740
10	United Kingdom	141	1,212	1,193	1,209
11	Poland		1,089	1,091	1,126
12	Niagara Falls, Canada	2	1,102	1,114	1,203

Хүснэгт 4-т БНСУ, Сингапур, Макао гэсэн Зүүн Азийн казиногийн тогтворжсон үйл ажиллагаа болон орлогоор тэргүүлэх зэргийн казино тоглоомын үйл ажиллагаа эрхлэгч улсуудын бооцоот тоглоомын төрөл, дотоодын иргэдэд нээлттэй эсэх, тухай асуудлыг хариуцах төрийн эрх бүхий байгууллага болон татварын хэмжээ зэрэг мэдээллийг харьцуулан үзүүлсэн байна.

Хүснэгт 4.

Улс	*Бооцоот тоглоомын асуудал эрхлэх эрх бүхий байгууллага*	*Бооцоот тоглоомын төрөл*	*Дотоодын иргэдэд нээлттэй эсэх*	*Татвар*	*Тоо, байршил*
1.Бүгд Найрамдах Солонгос Улс Эх Сурвалж: http://gaming.unlv.edu/abstract/south_koreaHYPERLINK “http://gaming.unlv.edu/abstract/south_korea.html”a.html	Үндэсний Бооцоот Тоглоомыг Хянах Хороо (National Gambling Control Commission)	- казино - хонжворт сугалаа, - морин болон дугуйн уралдаан (авто уралдаан зэрэгт спортын уралдаан тэмцээний бооцоо орно)	- 1968 онд зөвхөн гадаадын иргэдэд үйлчлэх нөхцөлтэйгээр үйлчилгээ явуулах эрх олгосон; - 2000 онд анх дотоодын иргэддээ үйлчилж эхэлсэн;	Татварын бодит хувь хэмжээ (Effective tax rate) 20%.	Казино: 17 - Сөүл: 3 - Инчон: 1 - Кангвондо: 2 - Кёнгжү: 1 - Пусан: 2 - Чежү: 8 **Нийт: 17**
2. Бүгд Найрамдах Сингапур Улс Эх Сурвалж: http://gaming.unlv.edu/abstract/singapore.html	Казиногийн Зохицуулах Газар (Casino Regulatory Authority)	- хонжворт сугалаа (үүнд хөл бөмбөг болон авто уралдаан зэрэгт спортын уралдаан тэмцээний бооцоо орно) - казино	- Дотоодын иргэд болон байнга оршин суугчид казинод нэвтрэх хураамж: 24 цаг - 100 ам. доллар, жилийн 2000 ам.доллар төлнө; (Казиногийн хяналтын тухай хууль, 33А Бүлэг 116 дугаар зүйл.)	Татварын бодит хувь хэмжээ 12-22%. Татварын хоёр шатлалтай: Бооцоот тоглоомоос олох нийт орлого (Gross Gaminig Revenue - GGR)-ын татвар хэмжээ: премиум үйлчлүүлэгчээс* сарын 5%, бусад үйлчлүүлэгчээс сарын 15%; (Казиногийн хяналтын тухай хууль, 33А Бүлэг 146 дугаар зүйл.) Мөн түүнчлэн бүх төрлийн бооцоот тоглоомоос олсон орлогод 7% бараа, ажил, үйлчилгээний татвар ногдуулна.	Казино: 2 - Сентоза арал: 1 - Марина Бэй: 1

3. Макао **-** ЗЗОБ Эх Сурвалж: http://gaming.unlv.edu/abstract/macau.html	Бооцоот Тоглоомыг Хянах болон Зохицуулах Товчоо Gaming Inspection and Coordination Bureau	- казино - pari-mutuel (тотализатор) - хонжворт сугалаа - спортын уралдаан тэмцээний бооцоо	- Дотоод болон гадаадын иргэдэд адил тэгш үйлчилнэ	Татварын бодит хувь хэмжээ 38-39 %. GGR-ын татвар хэмжээ: 35%,1.6%-ийг Макао Санд, 1.4% (SJM)**-д эсхүл 2.4%-ийг(бусад) дэд бүтэц (аялал жуулчлал) нийгмийн халамжийн санд тус тус төвлөрүүлнэ.	**Казино: 34** - Макаогийн хойг: 24 - Тайпа арал: 10

*Премиум үйлчлүүлэгч - гэж казинод тоглохыг өмнө банкин дахь дансандаа 100,000 ам. долларoос доошгүй хэмжээний мөнгө байршуулсан этгээдийг хэлнэ.
** SJM Sociedade de Jogos de Macau S.A. нь Макаод бооцоот тоглоомын үйл ажиллагаа явуулах эрх авсан 6 байгууллагын нэг.

2.2. Казино, бооцоот тоглоомын бизнесийн бусад салбарт үзүүлэх нөлөөлөл

Эдийн засгийн салбарт үзүүлэх нөлөөлөл: Бооцоот тоглоомын эдийн засагт үзүүлэх нөлөөллийг үнэлэхдээ дараах үзүүлэлтүүдийг тооцвол зохино:

- ***Улсын төсөвт орох орлого*** - хуулиар тогтоосон татварын орлогын хэмжээ болон бооцоот тоглоомын үйл ажиллагаанаас орох шууд бус татвар, лиценз, зөвшөөрлийн хураамж, үл хөдлөх хөрөнгийн албан татвар, аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, бараа, ажил үйлчилгээний хураамж тус тус орно;
- ***Төрийн үйлчилгээ*** - бооцоот тоглоомын үйл ажиллагаанаас олсон орлогыг төрийн үйлчилгээ (эрүүл мэнд, боловсрол, нийгмийн халамж болон дэд бүтэц г.м.)-нд зарцуулсан байдал;
- ***Дэд бүтцийн үнэлгээ*** - бооцоот тоглоомыг газрыг нээсэнтэй холбоотойгоор шууд болон шууд бус байдлаар барилга байгууламж, зам болон дэд бүтэц шинээр барьж байгуулах, хотыг болон орон нутгийг тохижуулсан болон сайжруулсан нь хөрөнгийн үнэлгээнд нөлөөлж байгаа эсэх;
- ***Дэд бүтцийн зардал*** - шинэ бооцоот тоглоомын газруудад үйлчилгээ үзүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор (зам засвар, нийтийн үйлчилгээ, цагдаа болон гал унтраах алба г.м.) төсвөөс хуваарилж буй хөрөнгийн хэмжээ.
- ***Шинээр бизнес бий болох болон хаагдах*** - бооцоот тоглоомын газар нээсэнтэй холбоотой шинээр бий болсон болон хаагдсан бизнесийн тоо. Бооцоот тоглоом дараах салбаруудад онцгой нөлөө үзүүлнэ: бусад төрлийн бооцоот тоглоомууд, зочид буудлын үйлчилгээ (буудал, зоогийн газар г.м.) барилга угсралт, дэлгүүр, аялал жуулчлал болон үзвэр үйлчилгээний салбарууд тус тус орно.
- **Үйл ажиллагааны ашиг** - бооцоот тоглоомын газар нээснээр үйл ажиллагааны ашиг/худалдааны хэмжээнд орох өөрчлөлт.
- ***Хувь хүний орлого*** - бооцоот тоглоомын газар нээснээр хувь хүний дундаж орлогод гарах өөрчлөлт болон ядуураltай холбоотой тоо мэдээ орно.
- Ү***л хөдлөх хөрөнгийн үнэлгээ*** - шинээр байгуулсан бооцоот тоглоомын газрын ойролцоох барилга байгууламжийн үнийн өсөлтөд орох өөрчлөлт зэргийг тооцно.

Түүнчлэн казино, бооцоот тоглоомын бизнес нь нийгмийн бусад салбарт хэрхэн нөлөөлж байгааг уг үйл ажиллагааг зөвшөөрөгч орон бүр тогтмол судлан, сөрөг нөлөөллийг бууруулах төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг байна.

Казино, бооцоот тоглоом нь эдийн засаг, аялал жуулчлалын салбарт нөлөөлөхөөс гадна гэмт хэрэг, гэр бүл, ажил эрхлэлт, эрүүл мэнд, жижиг дунд бизнес гэх мэт нийгмийн салбарт ихэвчлэн сөргөөр нөлөөлдөг байна. Хүснэгт 3-өөр мөнгөн бус хэлбэрээр нийгэмд нөлөөлөх нөлөөллийг тодорхойлохыг хичээсэн АНУ-ын “Казиногийн эдийн засаг болон нийгмийн салбарт үзүүлэх үр дагавар” судалгаанаас оруулав.

Хүснэгт 5. Нийгэмд үзүүлэх нөлөө (мөнгөн бус хэлбэрээр)

	Нөлөөллийн хүрээ	***Нөлөөллийн хэмжүүр***	***Боломжит нөлөөллүүд***
1	Бооцоот тоглоомын донтолт	Бооцоот тоглоомын донтолтоос эмчлүүлсэн, амиа хорлосон, хавсарсан байдлаар илрэх архи, тамхи, сэтгэцэд нөлөөлөх бодис зэрэг бусад төрлийн донтолтод өртсөн иргэдийн тоонд гарсан өөрчлөлтийг харьцуулан үнэлэх.	Эрүүл мэндийн байгууллагын ачаалал нэмэгдэнэ
2	Гэр бүл салалт	Гэр бүл салалт, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүмүүсийн тоо, бооцоот тоглоомын донтолтын улмаас үүссэн ажилгүйдэл болон болзошгүй бусад тэтгэмжийн хэмжээ.	Гэр бүлийн тогтвор, хүүхдийн хүмүүжил улмаар нийгэмд сөрөг нөлөөлөл үзүүлнэ
3	Гэмт хэрэг	Эмчилгээ болон урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал, бооцоот тоглоомтой холбоотой хууль сахиулах байгууллагын зардал /мөрдөн байцаах, шүүх, цагдаа, хорих г.м./.	Төрийн үйлчилгээний ачаалал, төсөвт ирэх дарамт нэмэгдэнэ
4	Ажил эрхлэлт		Бооцоот тоглоомын үйл ажиллагаа явуулж эхэлсэнтэй холбоотой шууд болон шууд бус байдлаар бий болсон орон тооны болон цагийн ажлын байрны тоо.
5	Амралт	Бооцоот тоглоомыг зөвшөөрснөөр иргэдийн амралтын хэв маягт орох өөрчлөлт.	Иргэдийн амралтын хэв маягт сөрөг нөлөө үзүүлнэ
6	Амьдралын түвшин / Эрүүл мэнд	Амьдралын төвшин /чанарт/-д гарах ерөнхий өөрчлөлт.	Амьдралын түвшин доошлох эрсдэлтэй
7	Шинээр бизнес бий болох болон хаагдах	Бооцоот тоглоомын газар нэвтрүүлснээр шинээр бий болсон болон хаагдсан бизнесийн тоо. Бусад төрлийн бооцоот тоглоомууд, зочид буудлын үйлчилгээ / буудал, зоогийн газар г.м./, барилга угсралт, дэлгүүр, аялал жуулчлал болон үзвэр үйлчилгээний салбар тус тус орно.	Олон жижиг бизнес дампуурах, хаагдах эрсдэлтэй
8	Мөнгө угаах	Мөнгөний эх үүсвэрийг нуун дарагдуулах буюу хууль ёсны тоглогчоос хожлын тасалбарыг худалдан авах, казиногийн чипийг гэмт хэрэгтэй холбоотой гүйлгээнд төлбөрийн хэрэгсэл болгон ашиглах	Төсвийн ил тод байдлын төвшин буурна, улс орны авлигын индексийн үзүүлэлтэд сөргөөр нөлөөлж, нийгмийн аюулгүй байдалд эрсдэл учруулж болзошгүй

Казино, бооцоот тоглоом нь төрийн орлого буюу төсөв, аялал жуулчлалын салбарт эерэг нөлөөлөх хэдий ч бусад салбарт нөлөөлөх нөлөөлөл нь сөрөг байдаг байна. Судалгаанаас харахад сөрөг нөлөөлөл нь дараах салбаруудад хүчтэй илэрнэ. Үүнд:

1. Хувь хүний орлого,
2. Гэр бүл,

3. Эрүүл мэнд,
4. Гэмт хэрэг,
5. Хувь хүний амьдралын чанар
6. Үл хөдлөх хөрөнгийн үнэлгээнд сөргөөр нөлөөлдөг байна.[40]

Нийгмийн салбарт үзүүлэх нөлөөлөл нь ихэвчлэн сөрөг нөлөөлөл байдаг байна. Нийгмийн салбарт үзүүлэх сөрөг нөлөөллийг дараах байдлаар ангилж болно. Үүнд:

- **Гэмт хэрэгт нөлөөлөх нь:** Казино, бооцоот тоглоомын үйл ажиллагаа эрхэлж буй орчинд үйлдэгдэж байгаа болон түүний нөлөөллийн хүрээнд үйлдэгдэж буй гэмт хэрэг нь төрлийн хувьд аль ч улс оронд хүнд, онц хүнд төрөлд ордог байна. Учир нь энэ орчинд үйлдэгдэж буй гэмт хэрэг зохион байгуулалттай, гэмт хэргийн бүлэглэлүүдийн хүрээнд, хил дамнасан, өргөн хүрээний хохирогчидтой, хугацааны хувьд үргэлжилсэн, байнга давтагдах, хэрцгий, нийгмийг цочроосон, төрийн өндөр албан тушаалтнууд оролцсон гэмт хэргүүд байдаг. Тухайлбал, мөнгө угаалт, авилгал, албан тушаал урвуулан ашиглах, хил дамнасан хүний наймаа, залилан, зохион байгуулалттай дээрэм, банкны дээрэм, мансууруулах бодисын худалдаа, хүний амь, бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэргүүд ихээр үйлдэгддэг байна.
- **Гэр бүлд нөлөөлөх нөлөөлөл:** Гэр бүл салалт, өрхийн орлого, хувь хүний ажил эрхлэлт, эрүүл мэнд, гэр бүлийн хүчирхийлэлд нөлөөлж энэ нь хүүхдийн хүмүүжил, төлөвшилд сөргөөр нөлөөлдөг болох нь тогтоогдсон байдаг. Австрали улсад 2011 онд зөвхөн энэ шалтгаанаар салсан гэр бүл 1600 бүртгэгдсэн байна. Гэр бүл салалтаас хохирсон хүүхдийн тоо үүнээс 2-3 дахин их байна.
- **Эрүүл мэндийн салбарт нөлөөлөх сөрөг нөлөөлөл:** энэ нь олон төрлийн донтолт үүсгэдэг байна. Бооцоот тоглоомын донтолт, сэтгэцийн эмгэг, согтууруулах болон мансууруулах бодисын донтолт, гэмт хэргийн донтолт түүнээс сурвалжит биеийн эрүүл мэндийн сөрөг нөлөөллүүд илэрдэг бөгөөд урт хугацааны эмчилгээ шаардагддаг байна.
- **Ажлын байрны нөлөөлөл:** Ажлын байр өсөн нэмэгдсэн мэт харагддаг ч бодит амьдралд хувь хүний орлого болон амьдралын чанарт бодитой өсөлт огт гардаггүй нь судалгаагаар тогтоогдсон.

2.3. Казино, бооцоот тоглоомын нийгэмд үзүүлэх сөрөг үр дагавраас хамгаалах механизм

Казино, бооцоот тоглоомын үйл ажиллагааг хуулиар зөвшөөрдөг улс орнууд төрийн бус байгууллага, олон нийтийн байгууллага, мөн казино, бооцоот тоглоомын асуудал эрхэлсэн төрийн байгууллага, тусгай сангууд энэ бизнесийн бусад салбарт үзүүлэх эерэг сөрөг нөлөөллийг хангалттай сайн судалж, шаардлагатай төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэн холбогдох хууль тогтоомжид хуульчлан тогтоодог хэдий ч гэмт хэрэг болон эрүүл мэнд, гэр бүл салалт, ажил эрхлэлтэд нөлөөлөх сөрөг нөлөөллийг төдийлөн арилгаж чаддаггүй болох нь гадаадын орнуудад хийгдсэн судалгаанаас харагдаж байна. *(Шаардлагатай бол* англи хэл дээрх харьцуулсан судалгааг захиалагчид хүргүүлж болно.)

Хүснэгт 5-аас зарим улсад авч хэрэгжүүлж буй арга хэмжээ болон үр дүнгийн талаарх мэдээллийг үзнэ үү.

[40]"The social and economic impacts of gambling executive summary " 2011, Robert J. Williams, Ph.D. Professor, Faculty of Health Sciences, and Coordinator, Alberta Gaming Research Institute University of Lethbridge.

Хүснэгт 6. Нийгэм, эдийн засагт үзүүлэх эерэг болон сөрөг үр дагавар, авч буй арга хэмжээ (Зарим гадаад орны туршлагаас)

Нөлөөллийн хүрээ	***Хэрэгжүүлж буй арга хэмжээ***	***Нөлөөллийн үр дагавао***
Бооцоот тоглоомын донтолт	Австралийн Засгийн газар, ТББ-ууд бооцоот тоглоомд донтохоос урьдчилан сэргийлэх, эмнэлгийн болон санхүүгийн зэрэг бусад холбогдох асуудлаар зөвлөгөө өгөх, тусламж дэмжлэг үзүүлэх төсөл, хөтөлбөрүүд хэрэгжүүлж байна...	...бооцоот тоглоомд донтсон этгээд нь эхнэр, нөхөр, үр хүүхэд болон гэр бүлийн бусад гишүүд, хамт ажиллагсад, ажил олгогч зэрэг 5-10 хүнд нөлөөлдөг гэж үзсэн байна. Австралид уг асуудлаас улбаалж жилд 1600 гэр бүл салалт бүртгэгддэг байна.
	Канадын Онтарио мужид бооцоот тоглоомоос олох нийт орлогын 2 хувийг бооцоот тоглоомын донтолттой тэмцэх, урьдчилан сэргийлэх, шаардлагатай судалгаа явуулахад зориулдаг...	...хэдий ч энэ нь дээр дурдсан асуудлуудыг шийдэхэд хангалтгүй хэмжээнд байгаа ба төсвөөс нэмэлт зардал шаардах юм.
Орлогын хэмжээ	Казино байгуулснаар олон тооны ажлын байр шинээр нэмэгдэнэ...	…гэвч шинээр казино байгуулагдсан бүсэд орлогын хэмжээ өсөөгүй. Казиногийн ажлын байрууд нь ихэвчлэн цалин хөлс багатай, хар ажил байна. (АНУ)
	Орлогын хэмжээ өсөөгүй хэдий ч нийгмийн халамжид үзүүлэх дарамтын хэмжээ буурсан (нэг хүнд ногдох ажилгүйдлийн даатгалын хэмжээ 17%-иар, нэг хүнд ногдох нийгмийн халамжийн тэтгэмж 13% -иар тус тус буурсан)…	... гэвч энэхүү бууралт нь 80-аад оноос ажиглагдаж эхэлсэн нийгмийн халамжийн хэмжээний буурах хандлагатай давхацсан байж болзошгүй. (АНУ)
Гэмт хэрэг	Гэмт хэргийн өссөн үзүүлэлт, гэмт хэргийн төрөл хүнд болон онц хүнд рүү өссөн.	...Макаогийн гэмт хэргийн түвшин: 2002 онд 9088 гэмт хэрэг бүртгэгдсэн бол 2008 оны байдлаар энэ тоо 50%-иар өссөн үзүүлэлт гарсан байна.
Ажил эрхлэлт	Атлантик Ситид казиногийн үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойш ажилгүйдлийн түвшин буурсан	…гэвч Атлантик Сити дахь ажилгүйдлийн хэмжээ нь муж улсын хэмжээнд өндөр хэвээр байсаар байна. (АНУ)
Шинээр бизнес бий болох болон хаагдах	Барилга угсралт, зочид буудал болон үзвэр үйлчилгээнээс олох орлого нэмэгдэнэ...	…казиногийн орчим дахь зоогийн газар, дэлгүүр болон бусад үйлчилгээний тоо буурсан. 1977 онд (анхны казино нээгдэхийн өмнөх жил) 242 зоогийн газар үйл ажиллагаа явуулж байсан бол 1996 он гэхэд 142 болтлоо буурсан байна. (АНУ) ...харин барьцаатай зээлийн газруудын тоо огцом өссөн байна. (БНСУ)
Аялал жуулчлал	Аялал жуулчлалыг нэмэгдүүлнэ, эдийн засгийн өсөлт эрчимжинэ...	...Иллинойс мужид усан онгоцонд байгуулагдсан казино шинжээчдийн урьдчилан таамаглаж байсан аялал жуулчлал болон эдийн засгийн өсөлтөд төдийлөн өөрчлөлт үзүүлж чадаагүй байна. Үйлчлүүлэгчид нь зочид буудал болон бусад дагалдах үйлчилгээ авахад хангалттай хугацаа зарцуулаагүй гэж дүгнэсэн байна. (АНУ Дээрх жишээ нь хил орчмын нутаг дэвсгэр дээр шинээр бий болох бооцоот тоглоомын газрын хувьд адил төстэй үр дүнтэй байх магадлал өндөр юм.)

Казино болон бооцоот тоглоомын нийгэмд үзүүлж буй сөрөг үр дагавраас хамгаалахдаа дараах механизмыг хэрэгжүүлж байна. Үүнд:

- Эрх зүйн орчин бүрдүүлэх. Казиногийн хяналтын хууль, эрүүгийн хууль, захиргааны хууль, гэмт хэргийн хууль, иргэний хууль, гэр бүлийн хууль, хүчирхийллийн эсрэг гэх мэт шаардлагатай бусад хууль тогтоомжид казиногоос үүдэлт сөрөг үр дагавраас хамгаалах механизмыг ихэнх улс суулгаж өгсөн байдаг. Гэвч энэ нь тэдний хүссэн болон бодит үр дүнд төдийлөн хүрч чаддаггүй бөгөөд хамгаалалтын бодит механизм болж чадахгүй байна.
- Судалгаа, мониторинг, үнэлгээг тогтмол хийх. Төрийн эрх бүхий байгууллага болон ТББ, олон нийтийн байгууллага, олон улсын байгууллагаас нөлөөллийн талаарх судалгаа, мониторинг, үнэлгээг тогтмол хийн, шаардлагатай гэж үзсэн төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг. Гэвч сөрөг нөлөөлөл, хохирол байсаар байх бөгөөд төдийлөн үр дүнд хүрэхгүй байна.
- Хяналтын систем сайн байх. Аялал жуулчлалын болон эдийн засгийн тусгай бүсүүдэд оршин суугчдын сайн дурын нийгэмлэгүүд нь төрийн эрх бүхий хамгаалалтын болон хяналтын байгууллагуудтай хамтран ажилладаг.
- Аюулгүй байдлыг хангах. Казино болон бооцоот тоглоомын үйл ажиллагаа эрхлэх бүсийн гэрэлтүүлэг, камержуулалт, ээлжийн эргүүлийн болон цэгийн хамгаалалтыг сайжруулах. Энэ нь АНУ-ын мужуудад маш сайн хийгдсэн байдаг гэж үзжээ.
- Нийгмийн сөрөг үр нөлөөг бууруулах арга хэмжээ авах. Гэр бүл болон хүүхдэд зөвлөгөө өгөх, хамгаалах, сургуулиас завсардсан болон бооцоот тоглоомд донтсон өсвөр насныхныг нийгэмшүүлэх сайн дурын байгууллагуудын үйл ажиллагааг төрөөс болон орон нутгаас казиногийн татвараас олсон орлогоор санхүүжүүлэх.
- Санхүүжилтийн эх үүсвэр бүрдүүлэх. Шаардлагатай судалгаа болон мониторинг, үнэлгээний судалгаануудыг Казиногийн сангийн хөрөнгөөр болон төр, орон нутгийн санхүүжилтээр тогтмол хийх.
- Жижиг, дунд бизнесийг санхүүжүүлэх. Казино тоглоомонд донтогчдын ар гэр болон жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчид, эмэгтэйчүүдийн эрхэлж байгаа бизнесийн үйл ажиллагааг казиногийн орлогоос санхүүжүүлэх.
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэх нөхцөлийг бүрдүүлэх. Тус бүсийн цагдаа, шүүхийн байгууллагыг шаардлагатай техник хэрэгсэл, санхүүжилтээр хангах гэх мэт маш олон арга хэмжээг авч байна.

Хэдийгээр дээрх орнуудад хууль тогтоомжийг сайжруулах, хамгаалалтын болон урьдчилан сэргийлэх олон тооны төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж байгаа ч казино болон бооцоот тоглоомоос үүдэлт гэмт хэргийн гаралт, гэр бүл болон хувь хүнд чиглэсэн сөрөг нөлөөлөл асуудал хэвээр байсаар байна.

ГУРАВ. КАЗИНО, БООЦООТ ТОГЛООМЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХИЙГ ЗӨВШӨӨРДӨГ ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА

3.1. БНСУ-ын туршлага

БНСУ-ын хувьд бооцоот тоглоомыг зарчмын хувьд хориглосон. Тухайлбал,

- Эрүүгийн хуулийн 246 дугаар зүйлд зааснаар “ашиг олох зорилгоор бооцоот тоглоом тоглосон болон бооцоо тавьсан этгээдэд 5 сая воноос дээшгүй мөнгөн торгууль ногдуулна”,
- 247 дугаар зүйлд зааснаар “ашиг олох зорилгоор бооцоот тоглоомын газар нээж ажиллуулахыг хориглож, энэхүү заалтыг зөрчсөн этгээдэд 3-аас дээшгүй жил хорих ял оноох, эсхүл 20 сая воноос дээшгүй мөнгөн торгууль ногдуулахаар” тус тус заасан байна.

Бооцоот тоглоомыг хориглосон хэдий ч, хязгаарлагдмал (аялал жуулчлалыг нэмэгдүүлэх г.м.) хүрээнд тусгай хууль батлан бооцоот тоглоомын дараах хэлбэрүүдийг зөвшөөрсөн:

1. Казиногийн тухайд дотоодын болон гадаадын иргэдэд хамаарах зохицуулалт ялгаатай байна. ***Орхигдсон уурхайн бүсийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх тусгай хууль*** (11 дүгээр зүйл)-д заасны дагуу Кангвон мужид байгуулагдсан казино нь дотоодын иргэдэд үйлчилж буй цорын ганц казино юм. ***Аялал жуулчлалыг хөгжүүлэх тухай хууль*** (3.5, 5 дугаар зүйл)-д заасны дагуу Соёл, спорт болон аялал жуулчлалын сайд нь зохих шаардлага хангасан дотоодын зочид буудлуудад зөвхөн гадаадын иргэдэд үйлчилгээ үзүүлэх казиногийн зөвшөөрөл олгодог байна.
2. Хонжворт сугалааг борлуулах үйл ажиллагааг БНСУ-ын Стратеги, сангийн яамны харьяа Хонжворт сугалааны хороо (Lottery Commission) эрхлэх ба ***Хонжворт сугалаа болон хонжворт сугалааны (шагналын) сангийн тухай хуулиар*** зохицуулагдахаар тусгасан байна.
3. Морин уралдааныг зөвшөөрөх ба Хүнс, хөдөө аж ахуй болон ойн аж ахуйн яам харьяалагдана. Үүнээс гадна дугуйн болон моторт завины уралдааныг ***Дугуйн болон моторт завины уралдааны тухай хуулиар*** зохицуулах бөгөөд Соёл, Спорт болон Аялал жуулчлалын яам хариуцдаг байна.
4. Одоогийн байдлаар цахим бооцоот тоглоомын үйл ажиллагааг зохицуулсан эрх зүйн зохицуулалт байхгүй байна. Солонгосын үндэсний цагдаагийн агентлагаас кибер гэмт хэргийг хянаж, тус хяналтыг эрчимжүүлэх зорилгоор 2000 онд Кибер гэмт хэргийг мөрдөн байцаах багийг 16 мужийн цагдаагийн албанд байгуулсан байна.
5. Казиногийн үйл ажиллагаа явуулахаар зөвшөөрөгдсөнөөс бусад газар автомат тоглоом (Slot Machine) ажиллуулахыг хориглосон байдаг.

23.3. дугаар зүйл. Зөвхөн гадаадын иргэдэд зориулсан казиногийн бизнестэй холбоотой онцгой нөхцөлүүд:

1. Аялал Жуулчлалыг Дэмжих Хуулийн 21-р зүйлийг үл харгалзан Соёл, спорт, аялал жуулчлалын сайд тус хуулийн 3 (1) 5-р зүйлийн дагуу дор дурдсан шаардлагуудыг хангасан, эдийн засгийн чөлөөт бүсэд гадаадын хөрөнгө оруулалт татаж казиногийн бизнес эрхлэх (зөвхөн гадаадын иргэдэд зориулсан казиногийн бизнес) зөвшөөрөл хүссэн этгээдэд зөвшөөрөл олгож болно:
   a. Эдийн засгийн чөлөөт бүсэд аялал жуулчлалын бизнест оруулж байгаа гадаадын хөрөнгө оруулалт нь 500 сая доллар буюу түүнээс дээш байх;
   b. Хөрөнгө оруулж буй мөнгө нь Гэмт Хэргээс Олсон Орлогыг Нуун Дарагдуулсныг Шийтгэх Тухай Хуулийн 2 зүйлийн 4-р дэд хэсэгт заасан гэмт хэргээс олсон ашиг биш байх;
   c. Ерөнхийлөгчийн Зарлигт заасан хөрөнгө оруулагчийн санхүүгийн байдал зэрэг шаардлагуудыг хангасан.
2. (1) зүйлийн дагуу казиногийн бизнес эрхлэх зөвшөөрөл авах гэж буй этгээд Ерөнхийлөгчийн Зарлигт заасны дагуу Соёл, спорт, аялал жуулчлалын сайдад өргөдөл гаргана.
3. (1) зүйлд заасан казиногийн зөвшөөрөл авахад шаардлагатай бизнес эрхлэх газар, бизнес эхлэх хугацаа гэх мэт холбогдох асуудлуудыг Ерөнхийлөгчийн Зарлигт тусгасан байна.
4. (1) зүйлд заасны дагуу казиногийн бизнесийн зөвшөөрөл авсан этгээд бизнесээ эхлэхдээ Аялал Жуулчлалыг Дэмжих Хуулийн 23 (1)-д заасан тоног төхөөрөмж, материаллаг баазтай байх ёстой.
5. Хэрэв (1) зүйлд заасны дагуу казиногийн бизнесийн зөвшөөрөл авсан этгээд дор дурдсан зөрчлийг гаргасан бол Соёл, спорт, аялал жуулчлалын сайд зөвшөөрлийг цуцална.
   1.4. (1) зүйлд заасан хөрөнгө оруулалт хийгдээгүй;

1.5. Хөрөнгө оруулж буй мөнгө нь Гэмт Хэргээс Олсон Орлогыг Нуун Дарагдуулсныг Шийтгэх Тухай Хуулийн 2 зүйлийн 4-р дэд хэсэгт заасан гэмт хэргээс олсон ашиг байвал;

2. Аялал Жуулчлалыг Дэмжих Тухай Хуулийн 11-р зүйлийг үл харгалзан (1) зүйлд заасны дагуу казиногийн бизнесийн зөвшөөрөл авсан этгээд казиногийн бизнес эрхлэхэд шаардлагатай материаллаг бааз, менежменттэй дурын этгээдэд казиногийн бизнесээ даалгаж болно. Ийм тохиолдолд дааж авсан менежер Аялал Жуулчлалыг Дэмжих Тухай Хуулийн 12-р зүйлд заасан эрх хасах үндэслэлд өртөөгүй байх ёстой.

3. Аялал Жуулчлалыг Дэмжих Тухай Хууль казиногийн бизнес эрхлэх зөвшөөрөлд энэ хуульд зааснаас өөрөөр үйлчилнэ.

Хуулийн эдгээр зохицуулалтаас харахад төрийн бодлогын хувьд эдийн засгийн үр өгөөж болон аялал жуулчлалыг нэмэгдүүлэх зорилгоор эдийн засгийн чөлөөт бүсдээ казино болон бооцоот тэмцээн уралдааныг хүлээн зөвшөөрөх бөгөөд БНСУ-ын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа 17 казино, бооцоот тоглоомын газруудаас зөвхөн нэг нь л дотоодын иргэдэд үйлчилдэг байна. Гэвч судалгаанд ашигласан казиногийн орлогын харьцуулсан мэдээллээс үзэхэд гадаадын иргэдэд үйлчилдэг казиногийн орлого дотоодын иргэдэд үйлчилдэгээс орлогын хувьд бага байна.

Хуулийн эдгээр зохицуулалтаас харахад төрийн бодлогын хувьд эдийн засгийн үр өгөөж болон аялал жуулчлалыг нэмэгдүүлэх зорилгоор эдийн засгийн чөлөөт бүсдээ казино болон бооцоот тэмцээн уралдааныг хүлээн зөвшөөрөх бөгөөд БНСУ-ын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа 17 казино, бооцоот тоглоомын газруудаас зөвхөн 1 нь л дотоодын иргэдэд үйлчилдэг байна. Гэвч судалгаанд ашигласан казиногийн орлогын харьцуулсан мэдээллээс үзэхэд гадаадын иргэдэд үйлчилдэг казиногийн орлого дотоодын иргэдэд үйлчилдэгээс орлогын хувьд бага байна.

Орлогын хэмжээ: БНСУ-ын казиногийн 2000-2011 оны орлогын харьцуулсан мэдээллийг доорх хүснэгтээс үзнэ үү.

Хүснэгт 7. Бооцоот тоглоомоос олсон орлогын хэмжээ, ам.доллараар

Он	*Кангвон-ленд казино (дотоодын иргэдэд)*	*Зөвхөн гадаадын иргэдэд үйлчлэх казино*	*Нийт*
2000	78,676,000	303,045,000	381,721,000
2001	354,042,000	298,350,000	652,392,000
2002	380,214,000	331,533,000	711,747,000
2003	557,928,000	334,740,000	892,668,000
2004	660,000,000	381,568,000	1,041,568,000
2005	813,400,000	426,006,000	1,239,406,000
2006	898,668,000	508,376,000	1,407,044,000
2007	1,108,620,000	661,932,000	1,770,552,000
2008	1,020,396,000	700,104,000	1,720,500,000
2009	912,687,000	726,484,000	1,639,171,000
2010	1,090,458,000	874,872,000	1,965,330,000
2011	1,078,987,000	1,027,299,000	2,106,286,000

Хүснэгт 8. Казиногийн үйл ажиллагаа явуулах эрх бүхий Компаниудын орлого, үйлчлүүлэгчдийн тоо

Байршил	*Казиногийн нэр (Үйл ажиллагаа явуулах эрх бүхий компани)*	*Зөвшөөрөл олгогдсон огноо*	*Ажилчдын тоо*	*Орлого (сая вон)*	*Нийт үйлчлүүлэгчдийн тоо*
Сөүл	Paradise Walkerhill Casino (Paradise Co. Ltd)	3.5.1968	855	295,881	368,419
	7 Luck Casino Gangnam (Grand Korea Leisure Co. Ltd)	1.28.2005	1,363	250,842	343,537
	7 Luck Casino Hilton (Grand Korea Leisure Co. Ltd)	1.28.2005	472	166,437	774,734
Пусан	7 Luck Casino Pusan Lotte (Grand Korea Leisure Co. Ltd)	1.28.2005	262	56,159	180,020
	Paradise Casino Pusan (Paradise Global Co. Ltd)	10.29.1978	249	70,452	83,947
Инчон	Golden Gate Casino (Paradise Incheon Co. Ltd)	8.10.1967	272	63,838	29,186
Кангвон	Alpensia Casino (Cozana Co. Ltd)	12.9.1980	30	294	4,334
Дэгү	Hotel Interbulgo Daegu Casino (Golden Cгэээмшдэг Co. Ltd)	4.11.1979	103	60	569
Чежү	Ramada Plaza Casino (Ace Trading Co. Ltd)	10.15.1975	149	12,673	19,903
	Paradise Grand Casino (Paradise Jeju Co. Ltd)	9.1.1990	130	20,972	30,522
	Beluga Casino &Resort (Beluga Co. Ltd)	7.31.1991	109	4,376	13,848
	Royal Palace Casino (Poonghwa Co. Ltd)	11.6.1990	98	10,620	9,174
	Lotte Hotel Jeju Casino (Doosung Co. Ltd)	4.11.1985	148	20,744	33,322
	The Hotel &Vegas Casino (TLC Leisure Co. Ltd)	9.1.1990	158	13,404	23,091
	Hyatt Hotel Casino (Unicorn Co. Ltd)	9.1.1990	74	5,424	5,640
	Golden Beach Casino (Golden Beach Co. Ltd)	12.28.1995	131	13,558	25,573
		Гадаадын иргэд	4603	1005734	1945819
Кангвон	Kangwon Land Casino (Kangwon Land Co. Ltd)	10.12.2000	1,697	1,256,850	3,091,209
Нийт: (дотоодын болон гадаадын иргэд)			**6300**	**2262584**	**5037028**

3.2. АНУ-ын туршлага

АНУ-ын Нью Жерси мужийн “Казиногийн хяналтын тухай хууль”[41] нь өргөн хүрээний зохицуулалттай бөгөөд 17 бүлэг бүхий том хууль байна. Тус хуулиар:

- Казиногийн Хяналтын Хороо болон Тоглоомын Албадлагын Хэлтсийн зохион байгуулалт, гишүүд болон бүтэц бүрэлдэхүүн, гишүүдийн ур чадвар, цалин хөлс, хориглох зүйлс, үйл ажиллагааны зардал, тус байгууллагын эрх үүрэг, хуулийг албадан сахиулах эрх болон үүрэг хариуцлага зэрэг казино, бооцоот тоглоомын үйл ажиллагаанд хяналт тавих, хууль сахиулах эрх бүхий байгууллагын тухай зохицуулалт эхний 5 бүлэгт орсон байна.
- Казино болон бооцоот тоглоомын тусгай зөвшөөрөл, түр казиногийн зөвшөөрөл, интернет тоглоомын тухай 6 дугаар бүлгээр зохицуулсан байна. Ингэхдээ казиногийн лицензийн нэмэлт төрлүүд, казиногийн лицензийн өргөдөл, өргөдөл гаргагчийн эрх, өргөдөл гаргагчид тавигдах шаардлага, нэмэлт шаардлагууд, лиценз олгоход шаардлагатай мэргэшил, лиценз олгохоос татгалзах шалгууруул, тусгай зөвшөөрөл эзэмшигчээс гаргасан тайлан болон зөвлөмжүүдийг хянан шалгах, мөрдөн шалгах, тусгай зөвшөөрөл эзэмшигчээс ирүүлэх шаардлагатай баримт бичиг, мэдээллүүд, казиногийн гол ажиллагчдыг лицензжүүлэх, ажиллагсдын бүртгэл, ажиллагсдын баталгаа, нэмэлт нөхцөлүүд, казиногийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрөл, хөдөлмөрийн байгууллагын бүртгэл, бүртгэл болон бусад тусгай зөвшөөрлийг батлах, татгалзах, казиногийн лиценз, тусгай зөвшөөрлийн болон бүртгэлийн хугацаа сунгах зэрэг харилцааг өргөн хүрээнд нь зохицуулсан байна.

Түүнчлэн түр казиногийн зөвшөөрлийн тухай бүлгээр түр казиногийн хамрах хүрээ, шаардлага, түр казиногийн (interim casino), түр казиногийн зөвшөөрлийн хүсэлтийг Казиногийн Хяналтын Хороо хүлээн авч хэлэлцэх, итгэлцлийн гэрээ, хүлээлгэх үүрэг хариуцлага, мэргэжлийн ур чадварыг тодорхойлох зэрэг асуудлыг хамруулан хуулийн зохицуулалтыг хийсэн байна.

- Казиногийн үйл ажиллагааны нөхцөлийг хуульчлан тогтоосон бөгөөд ингэхдээ үйл ажиллагааны гэрчилгээ, ажиллах цаг, казиногийн үйл ажиллагаанд шаардагдах байгууламж, дотоод хяналт, тоглоом болон тоног төхөөрөмж, жакпотын жил бүрийн төлбөр хүлээн авах эрх, зээл, данс үүсгэх, хязгаарлалт, мөнгөн гүйлгээний тайлан, казино болон зочид буудал дахь согтууруулах ундаа, тусгай зөвшөөрлийн түрээс болон гэрээ, үнэт цаас байршуулах болон ажил эрхлэлттэй холбоотой харилцааг зохицуулсан байна.
- Мөн дараах асуудлуудаар сонсгол хийх тухай зохицуулсан бөгөөд үүнд нотлох баримт бүрдүүлсэн журам, ял шийтгэлийг үл хүндэтгэх, дахин сонсгол, тусгай зөвшөөрлийн эсрэг үйл ажиллагаа, онцгой нөхцөл байдал, шүүхийн хэлэлцүүлэг зэрэг асуудлаар сонсгол хийнэ.
- Дараах тохиолдлуудад казино болон бооцоот тоглоомын үйл ажиллагаа эрхлэгчид ял шийтгэл оногдуулна. Үүнд: Лицензийн хураамжийн төлбөр болон бусад актын дагуу төлөх төлбөрөөс санаатайгаар зайлсхийсэн тохиолдолд оногдуулах ял шийтгэл, Хууль бусаар казино болон бооцоот тоглоомын үйл ажиллагаа эрхлэгчид оногдуулах ял шийтгэл, тоглоомын тоног төхөөрөмжүүдийг ашиглахтай холбоотой гэмт хэрэгт оногдуулах ял, бичил схем болон тоглоомын бэлдцийг хууль бусаар ашиглах, карт болон шоонд тэмдэглэгээ хийх, хууль бус зоос ашигласан тохиолдолд оногдуулах ял шийтгэл, төхөөрөмж, тоног төхөөрөмж буюу бусад материалыг хууль бусаар эзэмшсэн, үйлдвэрлэсэн, тараасан, худалдан борлуулсан эсхүл үйлчилсэн тохиолд оногдуулах ял шийтгэл, тусгай зөвшөөрөл эсхүл бүртгэлгүйгээр ажил эрхлэх гэх мэт хуульд заасан бусад тодорхой тохиолдлуудад оногдуулах ял шийтгэлийг хуульчлан тогтоосон байна.

[41] http://www.state.nj.us/casinos/actreg/act/

- Түүнчлэн казиногийн тусгай зөвшөөрлийн дэглэм, төлбөр болон татвар, дахин хөрөнгө оруулалт, улсын нөөцийн гэрээ, казиногийн үйл ажиллагааг олон сувгаар түгээх, мужийн онцгой байдлын ажиллагаа, Атлантик хотын аялал жуулчлалын дүүргийн эрх зүйн зохицуулалт болон холбогдох бусад харилцааг тус хуулиар зохицуулсан байна. Атлантик хотын аялал жуулчлалын дүүргийн талаарх тус хуулийн зохицуулалтад хотын аялал жуулчлалын дүүрэгт хамаарах тодорхойлолтууд болон хөгжлийн болон загвар удирдамж, газар ашиглах журам, аялал жуулчлалын дүүрэг байгуулсны дараах эрх бүхий байгууллагын үйл ажиллагаа болон маркетингийн хөтөлбөр, олон нийтийн аюулгүй байдлын төлөвлөгөө зэрэг анхаарвал зохих өргөн хүрээний харилцаанууд хамрагдсан байна.

“Казиногийн хяналтын тухай хууль”-ийн лицензийн төлбөр болон татварын зохицуулалт[42]:

139 дүгээр зүйл. Казиногийн лицензийн төлбөр.

а) Хэлтэс нь Казиногийн лиценз олгоход төлөх төлбөр болон түүний журмыг тогтооно. Лиценз олгосны төлбөрийг мөрдөн шалгах зардал болон тусгай зөвшөөрлийн өргөдлийн нөхөн төлбөрт үндэслэн тогтоох бөгөөд 200.000.00 ам. доллараас багагүй байх ёстой.

b) Мужийн Ерөнхий Прокурор нь Хэлтсийн хууль сахиулах чиг үүрэг болон мөрдөн шалгах бодит болон ирээдүйн зардлыг, Казиногийн Хяналтын Хорооны үйл ажиллагааны зардлыг суурь болгон жил бүрийн лицензийн болон сунгалтын төлбөрийг тогтооно.

c) Хэрэв тусгай зөвшөөрөл эзэмших өргөдөл батлагдсан бол казиногийн тусгай зөвшөөрлийн өргөдөл болон анхны тусгай зөвшөөрлийн хавсралт бүрийн төлбөрт шаардагдах 100.000.00 ам. доллараас дээш хэмжээний барьцааг эргэн төлөгдөхгүй нөхцөлтэйгөөр байршуулна.

140 дүгээр зүйл. Автомат машины тусгай зөвшөөрлийн төлбөр.

а) Хэрэв энэ хуулиар бусад нэмэлт татвар эсхүл төлбөр ногдуулсан бол түүн дээр нэмэн энэ Мужид байгуулагдсан тусгай зөвшөөрөл бүхий казино бүрд, эсхүл ашиглагдаж байгаа автомат тоглоом бүрд жил бүр 500.00 ам. долларын төлбөр ногдуулна.

Казиногийн Хяналтын тухай хуульд зааснаар Нью Жерси мужид үйл ажиллагаа эрхэлдэг казиногийн тусгай зөвшөөрөл эзэмшигч бүр дараах төрлийн татвар төлнө Үүнд:

- Нийт орлогын татвар (gross revenue tax) энэ нь хуульд зааснаар 8% байна.
- Хөрөнгө оруулалтын хоёр дахь татвар (investment alternative tax) 1.25-2.5%
- 148 дугаар зүйлийн 2-т заасан олон үйлдэлтэй, дэвшилтэт автомат тоглоомын машинд ногдуулах 8%-ийн татвар,
- мөн хуулийн 148 дугаар зүйлийн 3-т заасан Казиногийн тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тодорхой тодорхойлсон цэвэр орлогод ногдуулах 7.5%-ийн татвар.

Мөн тус хуульд зааснаар тусгай зөвшөөрөл эзэмшигчид нь хувь, хэмжээ тогтоосон татвар, казиногийн тусгай зөвшөөрлийн төлбөрөөс гадна бүртгэлийн, мөрдөн шалгах ажиллагааны, Хорооны зардлын, Казиногийн орлогын сангийн, Казиногийн Хяналтын Сангийн, эрх бүхий байгууллагын сангийн, нөхөн төлбөрийн зэрэг бусад төлбөр хураамж төлнө.

Казиногийн жилийн орлогын мэдээлэл: АНУ-ын хэмжээнд хувийн өмчийн нийт 426 казино үйл ажиллагаа явуулдаг бөгөөд түүнээс топ 20-д багтдаг эхний 20 казиногийн 2011-2012 оны орлогын харьцуулсан мэдээллийг доор хүснэгтээр оруулав.

[42]Нью Жерси мужийн “Казиногийн Хяналтын хууль”-ийн 16 дугаар бүлэг.

Хүснэгт 9. АНУ-ын казиногийн зах зээл дэх топ 20-ын орлогын харьцуулсан мэдээлэл[43]

Зэрэглэл	*Казиногийн зах зээл*	*2011 оны орлого*	*2012 оны орлого*
1	Las Vegas Strip, Nevada	$5.777 тэрбум	$6.207 тэрбум
2	Atlantic City, New Jersey	$3.573 тэрбум	$3.052 тэрбум
3	Chicago-land, Indiana / Illinois	$2.057 тэрбум	$2.243 тэрбум
4	Detroit, Michigan	$1.378 тэрбум	$1.417 тэрбум
5	Connecticut	$1.385 тэрбум	$1.230 тэрбум
6	Philadelphia, Pennsylvania	$816.31 сая	$1.167 тэрбум
7	St. Louis, Missouri / Illinois	$1.086 тэрбум	$1.108 тэрбум
8	Biloxi / Gulf Coast, Mississippi	$830.86 сая	$1.095 тэрбум
9	The Poconos, Pennsylvania	N/A	$715.65 сая
10	Tunica/Lula, Mississippi	$926.92 сая	$821.95 сая
11	Kansas City, Mo. (includes St. Joseph)	$753.44 сая	$799.85 сая
12	Boulder Strip, Nevada	$757.03 сая	$831.55 сая
13	Shreveport/Bossier City, Louisiana	$764.92 сая	$715.65 сая
14	Lake Charles, Louisiana	$639.13 сая	$686.99 сая
15	Yonkers, New York	$582.23 сая	$672.57 сая
16	Reno/Sparks, Nevada	$684.05 сая	$644.92 сая
17	Pittsburgh/Meadow Lands, Pennsylvania	$531.80 сая	$636.24 сая
18	Black Hawk, Colorado	$625.17 сая	$633.39 сая
19	Lawrence burg /Rising Sun/ Belterra, Indiana	$676.17 сая	$632.14 сая
20	New Orleans, Louisiana	$640.94 сая	$622.19 сая
21	Downtown Vegas, Nevada	$493.39 сая	$505.32 сая

Татварын мэдээлэл: Казино болон бооцоот тоглоом, тэмцээн уралдааны тусгай зөвшөөрөл эзэмшигчид нь муж бүрийн Казиногийн хяналтын тухай хууль, бооцоот тоглоом, тэмцээн уралдааны тухай хууль, журам, түүнчлэн мужийн болон улсын татварын холбогдох бусад хууль тогтоомжид зааснаар татвар болон бусад төлбөр, хураамж төлөх үүргийг хүлээнэ.

Хүснэгт 9-өөр АНУ-ын 22 мужийн казиногийн орлогын татварын мэдээллийг харьцуулсан бөгөөд үүнд татварын хувь хэмжээ, татварын хуваарилалтын талаарх харьцуулсан мэдээлэл багтана.

Хүснэгт 10. АНУ-ын мужуудын казино, бооцоот тоглоомын татварын харьцуулсан мэдээлэл[44]

Муж	*Татварын орлого*	*Татварын хуваарилалт*	*Татварын хувь*
Colorado	107.02 USD	-Орон нутагт, -Түүхэн болон дархан цаазат газарт, -Олон нийтийн байгууллага, -Ерөнхий санд	Тоглоомын орлогын татварын хамгийн дээд хэмжээ нь 20% байх бөгөөд татварын хувь нь шаталсан тогтолцоотой байна.
Delaware	243.12 USD	-Ерөнхий сан	Операторт үлдсэн орлогын 42.21%

[43]http://www.statisticbrain.com/casino-market-and-revenue-statistics/
[44]Gambling regulation in the NAFTA countries: A comparative analysis. By Magda Sanchez Navarro*.

Florida	140.83 USD	-Муж улсын боловсролын тогтолцоонд	42.79%
Illinois	466.07 сая USD	-Боловсролын туслалцаа, -Орон нутгийн засаг захиргаа	Нийт тоглоомын орлогод15%-50% хүртэл шаталсан татвар ногдуулах ба нэвтрэх татвар 2-3 долларын татвар авна.
Indiana	874.86 сая USD	-Эдийн засгийн хөгжил, -Орон нутгийн засаг захиргаа	Усан онгоцны болон газрын казино: нийт тоглоомын орлогын 15-40%, -байнгын үйлчлүүлэгч бүрээс нэвтрэх татвар 3 доллар, -Морин уралдаан: нийт тоглоомын орлогын 25-35%
Iowa	305.54 сая USD	-Дэд бүтэц, -Ерөнхий болон Их сургуулиудад, -Хүрээлэн байгаа орчин, -Аялал жуулчлалын төсөл, -Соёлын өв, -Ерөнхий сан	-Усан онгоцон дахь казиногийн нийт тоглоомын орлогын 22% хүртэл, -Морин тойруулгын болон ширээний 100 сая доллар дасван тоглоомын орлогын 24% хүртэл,
Kansas (Төрийн өмчит)	9.48 сая USD	-Төрийн өрийг бууруулах, -Дэд бүтэц сайжруулах, -Үл хөдлөх хөрөнгийн албан татварын хөнгөлөлт,	-22% төрийн татвар, -орон нутгийн татвар 3%, -Бооцоот тоглоомын судалгааны сангийн 2%,
Louisiana	571.96 сая USD	-Ерөнхий сан, -Шинэ Орлеон хотод -Олон нийтийн тэтгэврийн тогтолцоо, -Мужийн хотын тохижилт, -Бороотой өдөр сан.	-Усан онгоцон дахь казино- 21.5%, -Газрын казино- жил бүр 60 сая долларын татвар эсхүл нийт тоглоомын орлогын 21.5%-ийн аль ихийг сонгоно. -Морин уралдаан- моринд төлсөн нийт тоглоомын орлогын 18.5%, улсын цэвэр татвар 18.5%, орон нутгийн татвар 4%.
Maine	30.16 сая USD	-Боловсрол, -Эрүүл мэнд, -Хөдөө аж ахуй, -Бооцоот тоглоомын хяналтын зөвлөл, -Бангор хотод	-Гарын мөнгөний эсхүл нийт цалингийн 1%, -Нийт тоглоомын орлогын 39%, -Бангор хотын гудамжин дахь нийт тоглоомын орлогын 3%.
Maryland	15.87 сая USD	-Боловсролын итгэлийн сан, -Орон нутгийн буцалтгүй тусламж, -Жижиг дунд бизнес болон эмэгтэйчүүдийн эзэмшдэг бизнес	Операторт үйлдсэн орлогын 33 %
Michigan	311.41 сая USD	-Олон нийтийн аюулгүй байдал, -Нийслэлийн тохижилт, -Өсвөр насныхны хөтөлбөр, -Татварын хөнгөлөлт, -Хөршийн хөгжил болон тохижилт, -Дэд бүтцийн засвар, тохижилт	-Нийт тоглоомын орлогын 19% (Детройт хот 10.9%, Мичиган мужид 8.1%) -Жилд ногдуулсан төрийн болон орон нутгийн төлбөр, хураамж,

Mississippi	285.47 сая USD	-Орон сууцжуулах, -Боловсрол, -Тээвэр, -Эрүүл мэндийн үйлчилгээ, -Өсвөр үеийнхэнд зөвлөгөө өгөх хөтөлбөр, -Орон нутгийн олон нийтийн аюулгүй байдлын хөтөлбөрүүд	-Тоглоомын орлогод 8%, -Тоглоомын орлогод 4%-ийн нэмэлт татварыг орон нутгийн захиргаа ногдуулж болно.
Missouri	486.06 сая USD	-Боловсрол, -Орон нутгийн аюулгүй байдлын хөтөлбөр, -Бооцоот тоглоомын албан журмын судалгаа, -Цэргийн албан хаагчийн хөтөлбөр, -Бага насны хүүхдийн хөтөлбөр,	-Нийт тоглоомын орлогын 21%, -Үйлчлүүлэгчийн нэвтрэх төлбөр бүрт 2 ам.доллар,
Nevada	835.42 сая USD	-Боловсрол, -Орон нутгийн засаг захиргаа, -Ерөнхий сан, -Бооцоот тоглоомын бэрхшээлийг арилгах хөтөлбөр,	-Нийт тоглоомын орлогод ногдуулах хамгийн өндөр татвар 6.75%, -тойргийн болон орон нутгийн нэмэлт төлбөр, татварын ачааллыг харгалзан 1%
New Jersey	305.50 сая USD	-Өндөр настан, -Хөгжлийн бэрхшээл, хөдөлмөрийн чадваргүй иргэд, -Эдийн засгийг сэргээх хөтөлбөр,	-Нийт тоглоомын орлогын 8%, үүн дээр нэмээд орон нутгийн хөрөнгө оруулалтын 1.25% эсхүл 2.5%
New Mexico	64.31 сая USD	-Ерөнхий сан, -Бооцоот тоглоомын бэрхшээлийг арилгах хөтөлбөр	-Нийт тоглоомын орлогын 26%, -Хэтэвчний нэмэгдэл 20%, -Журамгүй бооцоот тоглоомыг журамлах, боловсруулах сангийн 0.25%,
New York	503.48 сая USD	-Боловсрол	Операторт үлдсэн орлогын 33.47%
Oklahoma	16.55 сая USD	-Боловсрол	Нийт тоглоомын орлогын 10-30%, Төрийн уралдааны хорооны 9%,
Pennsylvania	1.328 сая USD	-Үл хөдлөх эд хөрөнгийн татварын хөнгөлөлт, -Эдийн засгийн хөгжил, -Аялал жуулчлал, -Морин уралдааны үйлдвэрлэл, -Орон нутгийн засаг захиргаа	Автомат тоглоом: Төрийн тоглоомын сангийн 34%, -Морин уралдааны Хорооны 9%, -Эдийн засгийг хөгжүүлэх 5%, -Орон нутгийн засаг захиргааны 4% , Ширээний тоглоом: Ерөнхий сангийн 16-14%, Орон нутгийн засаг захиргаанд 2% татвар
Rhode Island	296.30 сая USD	-Ерөнхий сан	2010 оны санхүүгийн жилийн мэдээлэл. Операторт үлдсэн орлогын 27.33% -ийг татварт тооцон авсан
South Dakota	17.22 сая USD	-Аялал жуулчлалын яаманд-40% -Орон нутагт 10% -Хорооны санд 50%	Нийт тоглоомын орлогын 9%, -Тоног төхөөрөмжийн татварт жил бүр автомат машин бүрээс 2000 ам.доллар
West Virgina	378.49 сая USD	-Боловсрол, -Өндөр настан -Аялал жуулчлал	Операторт үлдсэн орлогын 45.86%-ийн татвар

3.3. Сингапур улсын туршлага

Хууль, эрх зүйн зохицуулалт: 2005 онд Сингапур Улсын Засгийн газар тусгайлан заасан хоёр газарт казиногийн үйл ажиллагаа явуулах эрх бүхий амралтын цогцолбор "integrated resport" байгуулах тендер зарласан. 2006 онд Казиногийн Хяналтын тухай хууль батлагдаж 2010 оноос казиногийн үйл ажиллагаа явуулж эхэлсэн байна.

Нийгэмд үзүүлэх сөрөг үр дагавраас урьдчилан сэргийлэх зорилгоор Казиногийн Хяналтын тухай хууль, холбогдох тогтоолуудад:

1. Казиногийн Хяналтын тухай хуульд казиногоор үйлчлүүлэх насны доод хязгаар: 21 (Казиногийн хяналтын тухай хууль, 33А Бүлэг, 180 дугаар зүйл) нас байхаар тогтоосон байна;
2. Дотоодын иргэд болон байнга оршин суугчид казинод нэвтрэх хураамжийн хэмжээ 24 цаг - 100 SGD нэг жилийн гишүүнчлэлийн хураамж - 2000 SGD байхаар тусгагдсан байна; (Казиногийн хяналтын тухай хууль, 33А Бүлэг 116 дугаар зүйл, Casino Control (Entry Levy) Regulations 2010 2010 No.S52)
3. Казиногийн дотор автомат теллер машин (ATM) байрлуулахыг ;
4. Дотоодын хэвлэл мэдээллийн хэрэгслээр тусгай зөвшөөрөлгүй авалгүй казиногийн үйлчилгээг сурталчлахыг; (Casino Control (Advertising) Regulations 2010 No.S86).
5. Премиум тоглогчдоос бусад дотоодын иргэдэд кредит картаар үйлчилгээ үзүүлэх (зээл олгох)-ийг; (Casino Control (Credit) Regulations 2010 No.S53) тус тус хориглосон байна.
6. 2012 онд Казиногийн хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, тодорхой иргэдийн казиногоор үйлчлүүлэх тоог хязгаарлахаар болсон байна. Тус арга хэмжээг Казиногийн хяналтын тухай хууль батлагдсантай холбогдуулан 2005 онд байгуулагдсан (National Council on Problem Gambling цаашид NCPG гэх) эрхлэн явуулж, дараах төрлийн хязгаарлалт тавьж болохыг тусгасан байна:
   - бооцоот тоглоомд донтсон иргэд сайн дурааараа NCPG-д бүртгүүлж, бооцоот тоглоомын газраар үйлчлүүлэх эрхээ (нэвтрэх тоог) хязгаарлуулах.
   - бооцоот тоглоомд донтсон иргэний гэр бүлийн гишүүд нь эрх бүхий байгууллагад хүсэлт гаргаж өөрийн гэр бүлийн гишүүний казиногоор үйлчлүүлэх эрхийг хязгаарлуулах.
   - урьд өмнө нь санхүүтэй холбоотой асуудалд орж байсан эсэх болон зээлийн түүхийг харгалзан бооцоот тоглоомын улмаас санхүүгийн хүндрэлд орох магадлал бүхий иргэдийн эрхийг эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрийн дагуу тус тус хязгаарлаж болохоор заасан байна.

Орлогын хэмжээ

Хүснэгт 11. Бооцоот тоглоомоос олсон орлогын хэмжээ, ам.доллараар

Он	*Казиногийн нэр (Үйл ажиллагаа явуулах эрх бүхий компани)*		*Нийт*
	Resorts World Sentosa (Genting-International Star Cruises Consortium)	*Marina Bay Sands (Las Vegas Sands Corporation)*	
2010	1,737,340,209	1,062,386,000	2,799,726,209
2011	2,144,343,082	2,364,922,000	4,509,265,082
2012	2,271,869,000	1,874,727,670	4,146,596,670
2013	1,858,579,000	845,140,420*	2,703,719,420

Аялал жуулчлалын статистик мэдээлэл

Хүснэгт 12. 2005-2013 оны зорчигч, жуулчдын мэдээлэл, мянга

Он	*2005*	*2006*	*2007*	*2008*	*2009*	*2010*	*2011*	*2012*	*2013*
Сингапурт ирсэн нийт гадаадын иргэдийн тоо	8943	9751	10284.5	10116.1	9682.7	11641.7	13171.3	14496.1	15495

3.4. Макао улсын туршлага

2009-2011 оны казиногийн зах зээлийн орлогын харьцуулсан мэдээллээр Макаогийн казиногийн зах зээл орлогоороо тэргүүлсэн үзүүлэлт гарсан байна. Энэ нь Макаогийн казиногийн зах зээлийн үйл ажиллагаа тогтворжсон, үйлчлүүлэгч олонтой байгаа нь харагдаж байна.

Хууль эрх зүйн орчин

1999 онд БНХАУ-тай нэгдсэнээр Макаогийн хууль эрх зүйн тогтолцоо шинэчлэгдсэн. Үүнээс хойш Макао БНХАУ-ын засаг захиргааны тусгай бүс болж Макаогийн эрх зүйн тогтолцооны гол онцлог нь ерөнхий хуульд тусгагдаж дээд төвшний автономит улс болжээ. Гэсэн хэдий ч Португалийн эрх зүйн өв уламжлагдан, иргэний хууль, худалдааны хууль, эрүүгийн хууль, захиргааны хууль зэрэг хуулиудад тусгалаа олжээ. Эдгээр хуулиуд нь Макаогийн казиногийн тухай ойлголтод чухал ач холбогдол үзүүлсэн. Худалдааны хууль нь мөрийтэй тоглоомын компаниуд ба гэрээний хууль зүйн үндсийг тогтоох ба бусад хувь нийлүүлэгчид, компанийн гаднах гэрээ хэлэлцээр, даатгалын гэрээ, банкны хараат бус байдлын баталгаа гэх мэт харилцааг зохицуулсан байна. Мөрийтэй тоглоомын хууль нь цогц, олон талын харилцааг зохицуулсан ба Макаод мөрийтэй тоглоомын тодорхой хууль эрх зүйн хүрээ нь хэд хэдэн тусгай хуулиуд дээр тулгуурласан байдаг байна.

Мөрийтэй тоглоомын “Ерөнхий хууль” нь казино тоглоомын үйл ажиллагааг зохицуулах холбогдох эрх зүйн орчныг бүрдүүлдэг гол хууль бөгөөд 2001/16 код бүхий хууль байна. Энэхүү ерөнхий тогтолцоо нь 26/2001 тоот захиргааны дүрмийн дагуу хэрэгжинэ.

2001/16 тоот Казино тоглоомоор ашиг олох үйл ажиллагаатай холбоотой хууль эрх зүйн орчны ерөнхий мэдээлэл:

Казиногийн тоглоомтой холбоотой зохицуулалтуудыг хийж буй 16/2001 тоот хууль нь дараах хэд хэдэн зорилготой. Эдгээр нь:

- Казино тоглоом тоглуулах үйл ажиллагаа эрхлэх,
- Удирдах болон хянаж буй этгээдүүд нь энэ үйл ажиллагаатай холбоотой үүрэг болон хариуцлага үүрэх,
- Гүйцэтгэхэд зохицсон байх,
- Казиногийн үйл ажиллагаа нь тэгш, шударга болон аливаа гэмт хэргийн нөлөөллөөс ангид байх,
- Казиногийн үйл ажиллагаа эрхлэх, удирдах болон хянаж буй этгээдүүд нь уг үүргийг гүйцэтгэхэд тохирох мэргэшил ур чадвартай байх,
- Макао тусгай захиргааны бүсийн энэ төрлийн тоглоомоос татвар цуглуулах эрх ашгийг хамгаалах,
- Макаогийн аялал жуулчлал, нийгмийн тогтвортой байдал болон эдийн засгийн хөгжлийг сайжруулах.

Энэхүү шинэ хууль эрх зүйн бүтцийн чухал нэг тал нь энэ төрлийн тоглоомын зах зээлд өрсөлдөөнийг нэвтрүүлж буй явдал юм. Хэдхэн жилийн өмнө тоглоомын үйлчилгээ нь зөвхөн нэг концесс эзэмшигчийн гарт монополь хэлбэрээр оршиж байсан. Шинэ хууль эрх зүйн бүтцийг үүсгэснээр 3 тоглоомын концесс эзэмшигч болон 2 дэд концесс эзэмшигч үйл ажиллагаагаа явуулж байна. Энэ нь тоглоомын үйл ажиллагаа эрхлэгчдийн дунд мөн шударга өрсөлдөөн явуулах сэдэл үүсгэж, үүнд анхаарал хандуулахад хүргэж байна.

16/2001 хуулийн дагуу Макаогийн тусгай захиргааны бүсэд үйл ажиллагаа явуулдаг казино болон тэдгээрийн концесс эзэмшигч нар нь тодорхой тоглоомын үйл ажиллагаа эрхэлж ашиг олох тусгай зөвшөөрөл авснаас хойш 3 жил хүртэл хугацаатайгаар ийм үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрнө. (олон талт, харилцан үйлчилдэг тоглоомуудын хувьд казино тоглоомын концесс эзэмшигч нь эдгээрийг тоглуулан ашиг олж болохгүй. Энэ төрлийн тоглоомоос ашиг олох нь казиногийн тоглоомоос ашиг олохтой холбоогүй үйл ажиллагаа юм.

24 төрлийн азын тоглоомыг аз турших тоглоом болгон баталсан. Гэхдээ нэмэгдэл тоглоомууд болон тус тусын дүрмийг Макаогийн тусгай захиргааны бүсийн гүйцэтгэх удирдлага зүгээс батлуулж болно. Тусгай захиргааны бүсийн гүйцэтгэх удирдлага мөн казиногийн байршил, урьдач нөхцөлийг тодорхойлно. Концессын хугацаа нь концессын гэрээнд заасны дагуу байх ба 20 жилээс илүү байж болохгүй. Гэхдээ шинэчилж болно.

Казино тоглоомын 3 концессыг Макаогийн тусгай захиргааны бүсийн гүйцэтгэх удирдлага олгоно. Хүчин төгөлдөр байгаа концессын гэрээнүүд нь дараах байгууллагуудтай хийгдсэн байна. Үүнд:

- Sociedade de Jogos de Macao (SJM), S.A. (1/4/2002 - 31/3/2020), MGM Grand Macau, S.A.-тэй хийсэн дэд концессын гэрээний хамт;
- Galaxy Casino S.A. (27/6/2002 - 26/6/2022), Venetian Macao, S.A.-тэй хийсэн дэд концессын гэрээний хамт (19/12/2002 - 26/6/2022);
- Wynn Resorts (Macao), S.A. (27/6/2002 - 26/6/2022).

Концессын гэрээний ажлыг авахын тулд дээрх тоглоомын компаниуд нь тусгай процедурыг дагах шаардлагатай. Казиногийн үйл ажиллагаа эрхлэх олон нийтийн тендер зарлагдсан бөгөөд энэ төрөөс зарласан тендер нь онцлог чанартай байсан байна. Учир нь тендерт оролцох боломж нь урьдчилсан шалгаруулалтад шалгарсан эсэхээр хязгаарлагдаж байсан. Түүнээс гадна концесст шалгарахын тулд, тоглоом тоглуулах эрх эзэмшигчид нь хэд хэдэн шаардлагыг биелүүлэх ёстой байдаг. Энэ нь тоглоомын эрх эзэмшигчдийг өндөр түвшинд хянах боломжийг тусгай захиргааны бүсийн гүйцэтгэх удирдлагад олгодог.

Өргөдөл гаргах нөхцөлийг хангаж буй өргөдөл гаргагч нар концесст шалгарахын тулд:

- Эдгээр компаниуд нь Макаод байгуулагдсан хувьцаа гаргагч компаниуд байна.
- Өргөдөл гаргагчид, тэдний гол хувь эзэмшигчид (жишээлбэл 5 хувиас дээш) болон гол гол албан тушаалтан, удирдлагын туршлага, санхүүгийн чадамж зэргийг үнэлэх шаардлагатай.
- Эдгээр компаниуд казино эрхлэх цорын ганц зорилготой байх.
- Бүсэд хууль ёсны үйл ажиллагаа эрхлэхийн тулд зээлийн дансандаа хамгийн багадаа 200 сая MOP (Макаогийн мөнгөн тэмдэгт) байршуулсан байх ёстой.
- ААН-ийн үндсэн хөрөнгө нь нэрлэсэн хувьцаагаар төлөөлөгдөж байх ёстой.
- Гүйцэтгэх захирал нь Макаогийн оршин суугч байх ба үндсэн хөрөнгийн 10-аас багагүй хувийг эзэмшигч байх бөгөөд түүнийг гүйцэтгэх засаглалаас томилно.
- Концесс эзэмшигч нь татвар болон хураамжийн төлбөр төлөх хангалттай санхүүгийн баталгаатай байх бөгөөд тусгай хандив, дэмжлэг үзүүлэхийг хүлээн зөвшөөрөх ёстой.

Концесс эзэмшигчийн казино тоглоомын үйл ажиллагаа нь тусгай захиргааны бүсийн гүйцэтгэх удирдлагын онцгой хяналтад байх бөгөөд дараах онцгой журмыг баримтална. Үүнд:

1. Компанийн хувьцаа, саналын болон бусад эрхээ бусдад шилжүүлэхэд заавал тусгай захиргааны бүсийн гүйцэтгэх удирдлагаас зөвшөөрөл авна.
2. Дэд концесс болон ашиглаж буй казино тоглоомын хөрөнгийг хэсэгчлэн эсхүл бүхэлд нь бусдад шилжүүлэх бол заавал тусгай захиргааны бүсийн гүйцэтгэх удирдлагын зөвшөөрлийг авсан байх шаардлагатай. Хэрэв Гүйцэтгэх удирдлагын зөвшөөрөлгүйгээр хэсэгчлэн ашиглах эрхгүй этгээдэд дэд концессыг шилжүүлсэн бол 300 сая МОР-аар, бүхэлд нь ашиглах зөвшөөрөлгүйгээр шилжүүлсэн бол 1 тэрбум МОР-оор концессын гэрээний дагуу торгууль төлнө.
3. Хувьцаа эзэмшигчид ийн хооронд компаниас гадуур гэрээ хэлцэл байгаа эсэхийг сурвалжилж Гүйцэтгэх удирдлагад мэдээллэх ёстой.
4. Концесс эзэмшигчид хуульд нийцсэн ААН-ын дүрэмд захирагдах ёстой.
5. Концесс эзэмшигчид нь Тоглоомын Хяналт, Зохицуулалтын Хорооноос баталсан тоглоомын аппарат, тоног төхөөрөмжийг Хорооны хяналтад казино болон бусад тоглоомын бүсэд байрлуулна.
6. Концесс эзэмшигч нь төлбөр, хураамж болон татварыг заавал төлөх үүрэгтэй бөгөөд төлбөрийн зохих баталгааг хангасан байна.
7. Концесс эзэмшигч нь Концессын гэрээ байгуулахдаа Макаогийн хөгжилд жинтэй хувь нэмэр оруулах үүрэг хүлээдэг.
8. Концесс эзэмшигч нь казиног тасралтгүй, хэвийн ажиллах нөхцөлийг хангах бөгөөд сурталчлах ёстой.
9. Концесс эзэмшигч нь зохиогчийн эрх, барааны тэмдэг, патент, оюуны өмчийн талаарх төрийн хууль, журмыг сахин биелүүлэх үүрэгтэй.
10. Тоглоомын концессын хугацаа дуусахад бүх эд хөрөнгө, мөнгөн хадгаламжаа Макаод буцаан өгөх ёстой.

Орлогын хэмжээ: Доорх хүснэгтээр 2002-2012 оны Макаогийн казиногийн тоо болон нийт орлогын харьцуулсан мэдээллийг үзүүлэв.

Хүснэгт 13. Бооцоот тоглоомын тоо болон орлогын хэмжээ

Он	*Казиногийн тоо*	*Тоглоомын ширээний тоо*	*Автомат тоглоом*	*Нийт орлого (сая патака)*	*Нийт орлого (сая ам.доллар)*
2002	11	339	808	22,180	2,772,500
2003	11	424	814	28,672	3,584,000
2004	15	1,092	2,254	41,378	5,172,250
2005	17	1,388	3,421	46,047	5,755,870
2006	24	2,762	6,546	56,623	7,077,870
2007	28	4,375	13,267	83,022	10,377,750
2008	31	4,017	11,856	108,772	13,596,500
2009	33	4,770	14,363	119,369	14,921,130
2010	33	4,791	14,450	188,343	23,542,860
2011	34	5,302	16,056	267,867	33,483,380
2012	34	5,485	16,585	304,139	38,017,380

Татварын орчин: Казиногийн орлогод ногдуулах татварын хувьд 2008 онд 5.4 тэрбум ам.долларын татвар улсын төсөвт оруулсан бөгөөд энэ нь төсвийн 70 хувийг бүрдүүлсэн байна.

Макаогийн казино болон бооцоот тоглоомын татвар нь дараах хувь хэмжээтэй байна. Үүнд:

- Тусгай тоглоомын албан татвар-35%
- Макаогийн Санд 1.6-2%
- Хотын хөгжил, аялал жуулчлал болон нийгмийн хамгаалалд 2.4-3%
- Жил бүрийн лицензийн төлбөр: концесс эзэмшигч бүр жилд 30 сая MOP
- Хувьсах татвар:
  - VIP ширээ бүр 300 мянган MOP
  - ширээ бүрээс 150 мянган MOP
  - автомат тоглоом бүрээс 1000 MOP

Бодит татварын хувь хэмжээ нь нийт тоглоомын орлогын 39%-аас их байна.
Морин уралдаан:

- Монополь концесс эзэмшигчийн жилийн төлбөр 15 сая MOP (2005 -2015 он хүртэл)
- Нохойн уралдаан:
- Монополь эзэмшигчийн жил бүрийн төлбөр 1 сая MOP (2006-2015 он хүртэл)
- Нийт тоглоомын орлогын 25%
- Хятад Лоттерей
- Лицензийн төлбөр жил бүр 0.5 сая MOP+23%+(5%+1%)*23%=24.38% зарсан лоттерей

Харин казино, бооцоот тоглоомын үйл ажиллагаа эрхлэгчид нь аж ахуйн нэгжийн орлогын албан татвар төлдөггүй байна.

* * *

АШИГЛАСАН МАТЕРИАЛ, ЭХ СУРВАЛЖ

- http://gaming.unlv.edu/
- http://www.korealaw.com
- http://www.ctrc.go.kr
- http://statutes.agc.gov.sg
- http://www.gambling-law-us.com/State-Laws/
- http://www.state.nj.us/casinos/actreg/act/
- http://www.legalinfo.mn/law/details/34?lawid=34
- http://www.communityresearchpartners.org/uploads/publications/Casino%20Social%20Effect%20 1-21-10.pdf “The Social Impact of Casinos: Literature Review and Cost Estimates January 21, 2010”
- http://www.gla.ac.uk/media/media_34552_en.pdf “Research on the Social Impacts of Gambling, Dr Gerda Reith, University of Glasgow with The Scottish Centre for Social Research (ScotCen)”
- https://estudogeral.sib.uc.pt/bitstream/10316/14183/1/CASINO%20GAMING%20LAW%20IN%20 MACAU.pdf “Casino gaming law in macau * alexandre libyrio dias pereira
- Casino Control Act (CHAPTER 33A) Act 10. of 2006 of Singapore
- Criminal Code, 3 October 1953, Republic of Korea
- Special Act on the Assistance to the Development of Abandoned Mine Areas Act No. 5089, Dec. 29, 1995 Republic of Korea
- Tourism Promotion Act Act No. 5654, Jan. 21, 1999 1995
- Casino Control act No. 2006/10 of Macao
- Casino Control Act, New Jersey of USA
- Act on Designation and Operation of Free Economic Zones (Republic of Korea
- СТ-14/206 “Казино, бооцоот тоглоомын үйл ажиллагаа эрхлэхийг зөвшөөрдөг гадаадын зарим орны туршлага, эрх зүйн зохицуулалт” харьцуулсан судалгаа.